

ПРОФАЙЛИНГ, ТҮҮНИЙГ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Г.Болортунгалаг

*Хилийн албаны сургуулийн
Хилийн боомтын аюулгүй байдал,
шалган нэвтрүүлэх албаны
тэнхимийн ахлах багш, Аюулгүй
байдал судлалын докторант, дэд
хурандаа*

Товч агуулга: Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл худлыг илчилж, үнэнийг тогтоохыг байнга эрэлхийлж ирсэн билээ. Нийгмийн хөгжлийн явцад худал, үнэнийг тогтоох арга барил улам боловсронгуй болж, өнөө үед шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг түлхүү ашиглах болсон.

Профайлинг (англ. *profile* — "хувийн мэдээллийн тойм") гэдэг нь хүний биеэ авч яваа байдал, гадаад төрх, зан авирын онцлог шинжүүдийг ажиглан тухайн хүний сэтгэл зүйн төлөв байдал болон хандлагыг тодорхойлох арга юм. Энэ аргыг товчхондоо "хүнийг унших арга" гэж ойлгож болно. Тухайн хүний зан чанар, үзэл бодол, хэрэгцээ, хандлага зэргийг богино хугацаанд тодорхойлох, дотоод мэдээллийг нь илрүүлэх боломж олгодог.

Анх гэмт хэргийн халуун мөрөөр үл танигдах этгээдийн сэтгэл зүйн хөргийг гаргахад ашиглагдаж байсан бөгөөд үүнийг 1888 онд Английн мэс засалч Томас Бонд зууны гэмт хэрэгтэн Жэк Потрошителийг илрүүлэх

оролдлогоор эхэлсэн гэж үздэг. Профайлингийн онол, арга зүйн суурийг П. Экман, В. Фризен, К. Шерер, М. Цукерман, Б. ДеПаул, В. А. Лабунская, О. Фрайя нарын судалгаа бүтээлүүд бүрдүүлдэг.

Түлхүүр үг: Шалган нэвтрүүлэх алба, профайлинг, зөрчил

Удиртгал

Орчин үед профайлингийг хүний ой санамжид хадгалагдсан "нуугдмал мэдээлэл"-ийг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой арга хэмээн үздэг. Энэ аргыг нийгмийн бүхий л салбарт нэвтрүүлэн ашиглах боломжтой бөгөөд олон улсын практикт гэмт хэргийн нууц далд шинж чанарыг илрүүлэх, ээдрээтэй хэрэг маргааныг шийдвэрлэх, нотлох ажиллагаанд өргөн ашигладаг. Түүнчлэн хүний нөөцийн болон албаны шалгалтын үнэн бодит байдлыг тогтооход ч хэрэглэж байна.

Харин хамгийн маргаантай асуудал нь "угсаатны профайлинг" юм. Энэ нь тодорхой угсаатны бүлгийн хүмүүсийг гэмт хэрэгтэй хамааралтай гэж үзэх хандлагатай холбоотойгоор хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэлтэй. Өнөөдөр профайлингийг дараах салбаруудад түлхүү ашиглаж байна. Үүнд:

- Гэмт хэрэгтний хэв шинж судлал
- Криминологи (гэмт хэргийн зан үйлийн судалгаа)

- Сэтгэцийн эрүүл мэндийн судалгаа (психологи, психиатр)
- Шинжилгээ, нотлох баримтын судалгаа
- Ял эдлүүлэх ажиллагаа (пенитанцар систем)

Мөн хил, гааль, цагаачлалын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд өргөн хэрэгжиж эхлээд байна. Улсын хил бол зөвхөн газар нутгийн хязгаар биш, хүний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөл үзүүлдэг онцгой орон зай юм. Судалгаанаас үзэхэд, ижил нөхцөлтэй гамшиг хилийн гадна гарвал хөндлөнгийн мэт хүлээн зөвшөөрөгдөх бол, дотроо үүсвэл илүү соргог, эмзэг хүлээн авдаг нь тогтоогдсон байдаг (Psychological Science).

Бид өөрсдөө ч улсын хилээр нэвтрэхдээ бахархах, хүндэтгэх мэдрэмжийн зэрэгцээ айдас, болгоомжлол, сандрал зэргийг мэдэрч явдаг. Энэ сэтгэл зүйн нөлөөллийн тухай Оросын яруу найрагч В. И. Маяковский “Зөвлөлтийн паспорт”, Монголын яруу найрагч Б. Лхагвасүрэн “Улсын хил дээр бичсэн шүлэг”-тээ тод томруун дүрсэлсэн байдаг. Аялал жуулчлалын өсөлт нь зөвхөн эерэг урсгал төдийгүй гэмт хэрэгтнүүдийн хилийн зааг давах оролдлого, урсгалыг ч нэмэгдүүлдэг. Үүнд террорист үйлдэл, хүний наймаа, зэвсгийн хууль бус наймаа, хар тамхи, мансууруулах бодис, бохир мөнгө угаалт, эрэн сурвалжлагдаж буй этгээдүүд багтдаг. Эдгээр

этгээдүүд хуурамч бичиг баримт ашиглан Монгол Улсад хориглосон бараа, үйл ажиллагааг нэвтрүүлэхийг эрмэлздэг.

Үндсэн хэсэг

Профайлингийн аргыг нислэгийн өмнөх бүртгэл болон онгоцонд суулгах үе шатанд зорчигчдод хяналт тавих замаар алан хядагчдыг илрүүлэхэд амжилттай ашиглаж байна. Энэхүү аргыг анх Израилын "Эль-Аль" (El Al) агаарын тээврийн компани нэвтрүүлснээр дэлхийн хамгийн аюулгүй нислэгийг гүйцэтгэдэг компани болсон. Энэ жишгийг олон улс даган хэрэгжүүлж байна.

Манай өвөг дээдэс ч мөн төрөлхийн “профайлерууд” байжээ. Хүнийг мэндлэх, уулзах, тамхилах үйлдлээр нь хэн болохыг тандах, таних уламжлалтай байв. “Тавхан үгэндээ танигдаад байна”, “Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг” гэх мэт хэлц үгс ч энэ ажигч, тандах, дүгнэх соёлын илрэл юм. Монгол мэндчилгээ бол орчин үеийн нэршлээр “тандах, чиглүүлэх ярилцлага” буюу жинхэнэ монгол профайлинг билээ.

Харин өнөөдөр Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх албаны албан хаагчид профайлингийн нарийвчилсан ойлголтгүй, тусгайлсан сургалт, хөтөлбөрт хамрагдаагүй байгаа нь анхаарах асуудал юм. Тэд олон жилийн туршлага, мэргэжлийн зөн

совингоор тухайн хүнийг таньж, таамаг дэвшүүлдэг ч энэ нь орчин үеийн мэргэшсэн арга зүйг орлож чадахгүй.

Сүүлийн жилүүдэд технологид тулгуурласан хяналт шалгалт өргөн хэрэглэгдэж байгаа ч, зөвхөн техникээр хууль бус үйлдлийн сэдлийг тодорхойлох боломжгүй. Хүний хүчин зүйлийг хэзээ ч орхигдуулж болохгүй. Профайлингийн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн шалгагч гэмт этгээдийг түүний харьцаа, хандлага, дохио зангаа, биеийн хэлэмж, сэтгэл зүйн илрэл зэргээр таньж, оновчтой шийдвэр гаргах боломжтой байдаг. Ийм чадвартай хүнийг “профайлер” хэмээн нэрлэдэг.

Дүгнэлт, санал

Профайлинг нь шалган нэвтрүүлэх боомт (ШНБ) дээр аюул тээгч этгээдийг илрүүлж, хувь хүн, нийгэм, төр, улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах үр дүнтэй аргачлалын нэг мөн.

Профайлинг нь аюулгүй байдлыг хангах бүхий л салбарт ашиглаж болох, зардал багатай хэр нь өндөр үр дүнтэй, практик ач холбогдол бүхий арга юм.

Арга зүйн хувьд профайлинг гэмт сэдэл бүхий, аюул дагуулж болзошгүй этгээдийн харьцаа, хандлага, сэтгэл хөдлөлийн өөрчлөлт, бусдаас ялгарах шинж тэмдгүүд болон эзэнгүй эд зүйлсэд үзлэг хийх зэргээр илрүүлэх боломж дээр суурилдаг.

Энэхүү аргыг нийгмийн сэтгэл зүйн үндсэн аргуудын нэг болгон ашиглаж, хүмүүсийн харилцаа, тэдний дотоод болон гадаад мэдээлэлд хандах хандлагыг ажиглан, хяналт тавих замаар үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Шалгагч нарын хувьд ажигч гярхай байдал, орчны өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлэх чадвар онцгой чухал үүрэгтэй.

Профайлинг нь шалгагчид богино хугацаанд, хязгаарлагдмал нөхцөлд, хангалт, нөөц хомс үед ч тухайн этгээдийн сэжиг бүхий сэдлийг зөв тодорхойлон “унших”, аюулыг урьдчилан илрүүлж, таслан зогсоох боломжийг олгодог.

Энэ арга нь үйл ажиллагаагаа тухайн цагийн нөхцөл байдалд үнэлж, орчны сэжигтэй шинж тэмдгийг танин мэдэх, улмаар стандарт бус нөхцөлд зөв шийдвэр гаргах чадамжийг шалгагчаас шаарддаг.

Хил залгаа болон бусад улс орнуудын туршлагаас харахад, ШНБ дээр “Профайлинг”, “Полиграф” аргуудыг олон жилийн турш амжилттай ашиглаж ирсэн нь эдгээр аргуудын практик үр нөлөөг баталж байна.

Монгол Улсын үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангахын тулд профайлингийн мэдлэг, ур чадвартай шалгагчдыг бэлтгэх, тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах, мөн сурах бичиг, гарын авлага боловсруулан хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай.

Монгол Улсын нөхцөл, онцлогт тохирсон “Шалган нэвтрүүлэх албаны /гаалийн/ профайлинг”-ийн арга зүй, загварыг бүрдүүлж, нэвтрүүлэх нь хамгийн тулгамдсан зорилт юм.

Шалгагч нь зөвхөн бичиг баримт шалгадаг, тамга дардаг мэргэжилтэн” байх шаардлагатай. Үүнийг мэргэжлийн байгууллагууд хүлээн зөвшөөрч, дэмжих нь зүйтэй.

Эх сурвалж

1. Paul Ekman – *Telling Lies: Clues to Deceit in the Marketplace, Politics, and Marriage*
Хүний нүүрний хувирал, биеийн хэлний шинжилгээгээр худлыг таних тухай сонгодог бүтээл.
2. Joe Navarro – *What Every Body Is Saying: An Ex-FBI Agent's Guide to Speed-Reading People*
АНУ-ын ХМТ-ийн агент асан хүний профайлинг хийх арга зүй, биеийн хэлний тайлал.
3. Brent E. Turvey – *Criminal Profiling: An Introduction to Behavioral Evidence Analysis*
Гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээ, профайлингийн мэргэжлийн гарын авлага.
4. David V. Canter – *Investigative Psychology: Offender Profiling and the Analysis of Criminal Action*

техник ажилтан биш харин сэтгэл зүйч, угсаатан судлаач, магадлан шинжээч, олон улс судлаач, хил судлаач, хэл шинжээч, профайлер зэрэг олон талт мэдлэг, чадвар бүхий “супер

Гэмт хэрэгтний зан үйлийг судлахад профайлингийн үүрэг.

5. El Al Airlines' Security Model – Израйлын El Al агаарын тээврийн компанийн профайлинг ашигласан хамгаалалтын жишээ (олон улсын туршлага).

6. Psychological Science Journal
Улсын хил, орон зайн өөрчлөлт сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдгийг судалсан судалгааны өгүүллүүд.

7. INTERPOL болон ICAO (International Civil Aviation Organization)

Хилийн шалгалт, зорчигчийн профайлингийн арга зүй, зааварчилгаа.

8. Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын сургалтын гарын авлага, дүрэм журам (дотоод хэрэглээний материал, зарим нь нууцлалтай байж болно)

9. Б.Лхагвасүрэн – “Улсын хил дээр бичсэн шүлэг”, В.В.Маяковский – “Зөвлөлтийн паспорт”

Хилээр нэвтрэх үед хүний сэтгэл зүйд төрөх мэдрэмжийн утга зохиолын дүрслэл.